



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**  
*/2021 оны байдлаар/*

УЛААНБААТАР ХОТ  
2021 ОН

## ТАНИЛЦУУЛГА

### *Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай*

Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг 2021 оны байдлаар танилцуулж байна.

Засгийн газар 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 203 дугаар тогтоолоор баталсан бөгөөд төлөвлөгөө нь 6 бодлого, 259 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 1087 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2021 оны байдлаар **74.5 хувийн /өссөн дүнгээр 19.5 хувь/** хэрэгжилттэй байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг бодлого тус бүрээр харуулбал:

- КОВИД-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого- 88 хувь,
- Хүний хөгжлийн бодлого- 78.5 хувь,
- Эдийн засгийн бодлого- 70.9 хувь,
- Засаглалын бодлого - 76.6 хувь,
- Ногоон хөгжлийн бодлого - 65 хувь,
- Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого- 79 хувийн хэрэгжилттэй байна.

Мөн төлөвлөгөөнд 2021 оноос хэрэгжүүлэхээр заасан боловч санхүү, хөрөнгө оруулалтаас шалтгаалан **хэрэгжиж эхлээгүй 21 арга хэмжээ** байна. Тухайлбал:

- 2.1.3.3.Сүрьеэгийн эмнэлэг барьж, ашиглалтад оруулна.
- 2.2.3.1.Тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадмыг зохион байгуулах шаардлага хангасан, олон улсын жишигт нийцсэн 30.000-40.000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн барьж ашиглалтад оруулна.
- 3.6.4.2. Ховд, Дорнод, Хөвсгөл аймгуудын нисэх буудлуудыг 4 С ангиллын олон улсын нисэх буудал болгон хөгжүүлэх төслийг эхлүүлнэ.
- 3.3.12.1. Мах, ногооны хадгалалт борлуулалтын цогцолбор байгуулах.
- 2.6.1.4. Үндэсний урлагийн их театрын шинэ барилга.
- 3.2.1.5.1.Асгатын мөнгөний ордын туршилт судалгааны хөрөнгө оруулалт.
- 3.6.1.1.Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд цахилгаан болон хийн эх үүсвэрээр ажиллах тээврийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлж, парк шинэчлэлтийг хийнэ /900ш/
- 3.7.9.1. Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд "Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 4.1.7.1.Мэдээлэл, холбооны өндөр технологи-инновацийн кластер байгуулна.
- 3.6.2.3.2.Улаанбаатар хотын баруун зүүн хэсэгт төрөлжсөн тээвэр, логистикийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулж, хөгжүүлнэ.

- 6.1.5.2. Цахилгаан соронзон тээврийн төслийг хэрэгжүүлж эхэлнэ.
- 6.1.11.4."Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк"-ийн инженерийн дэд бүтцийг гадаадын зээл, тусламж, төр хувийн хэвшлийн түншлэл, төсвийн хөрөнгө оруулалтаар барьж, үйлдвэрүүдийг үе шаттайгаар байгуулна.г.м

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 6 бодлогын хүрээнд үр дүнтэй хэрэгжиж байгаа зорилт, арга хэмжээнээс дурдвал:

**Нэг. КОВИД-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээнд:**

- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар **хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 100.0 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн** бөгөөд энэхүү арга хэмжээнд 2021 онд 1,455.2 тэрбум төгрөг зарцуулаад байна.

- Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг үе шаттай чөлөөлж, хөнгөлснөөр 2021 онд нийт **аж ахуйн нэгж, даатгуулагч нийтдээ 150.1 тэрбум төгрөгийг өөртөө** авч үлдсэн байна.

- Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын дагуу төрөөс хариуцах цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн санхүүжилтэд **612.0 тэрбум төгрөг төлөвлөснөөс энэ оны эхний хагас** байдлаар **561.4 тэрбум төгрөг** олгогдоод байна.

- 2021 оны 4 дүгээр сард цар тахлын өндөржүүлсэн бэлэн байдлын үед Монгол Улсын иргэн бүрд **300 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгоход 1.0 их наяд төгрөг зарцуулав.** 2021 оны 5 дугаар сард Ковид-19 цар тахлын эсрэг вакцины эхний тунд хамрагдсан 2.2 сая насанд хүрэгчдэд 50 мянган төгрөгийн урамшуулал олгоход 110 тэрбум төгрөг тус тус зарцуулаад байна.

- 145,199 татвар төлөгчийн хуульд заасан хугацаанд төлөөгүй **64.5 тэрбум** төгрөгийн татварыг 2020 онд **татварын алданги, торгуулиас чөлөөлсөн.**

- Улсын хэмжээнд **2022 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар** нийт хүн амын коронавируст халдварын эсрэг вакцины **нэгдүгээр тунд 2,269,541 хүн буюу 69.8 хувь, хоёрдугаар тунд 2,170,323 хүн буюу 66.7 хувь, гуравдугаар тунд 1,004,328 мянган иргэн** хамрагдсан байна.

- Цар тахал эхэлсэн хугацаанаас хойш буюу 2020.02.01-2021.05.31-ний хооронд агаарын замаар 183 нислэг үйлдэж 29 543, Монгол-Хятадын боомтоор 4301, Монгол-Оросын боомтоор 2516, **нийт 36 360** Монгол иргэдээ эх оронд нь ирүүлэх ажлыг зохион байгуулсан.

**Хоёр. Хүний хөгжлийн бодлогын хүрээнд:**

- “Эмнэлэгт үзүүлэх цаг захиалгын 1800-0119 нэгдсэн төв”-ийг нээж, ашиглалтад оруулан, иргэд эмнэлэгт **биеэр очиж цаг авдаг очер, дараалал сарын дотор 86 хувиар буурч,** иргэд чирэгдэлгүй тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүллээ.

- БШУ-ны сайдын 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн “Цэцэрлэгт ээлжийн багш ажиллуулах тухай” А/214 дүгээр тушаалаар **2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн 40-өөс дээш хүүхэдтэй бүлэгт ээлжийн багш**

**ажиллуулах, түүнд зарцуулах зардлыг шийдвэрлүүлэн, бэлтгэл ажлыг хангав.** Тус шийдвэр нь цэцэрлэгт ээлжийн багш ажиллуулах, багш нарын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, сургалт, үйл ажиллагаанд бэлтгэх, өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлж байгаа болно.

- **2021 оны байдлаар 40 цэцэрлэг, 32 сургууль, 5 спорт заал, 12 дотуур байрыг ашиглалтад хүлээн аваад байна.**

- Цахим сургалтын нэгдсэн платформ бий болгож, цахим хичээлийн сан бүрдүүллээ.


- Нийгмийн халамжийн үйлчилгээнд цахим систем нэвтэрсэнээр 39 нэр төрлийн баримтыг өөрийн биеэр халамжийн байгууллагад ирж бүрдүүлэх шаардлагагүй болж, тухайн иргэний мэдээллийг төрийн мэдээллийн нэгдсэн сангаас авч **10 төрлийн халамжийн үйлчилгээ, нийгмийн даатгалын 12 төрлийн үйлчилгээг цахимжуулаад** байна.

- 2021 оны 7 дугаар сараас эхлэн хүүхдээ гэртээ харж байгаа аав нь хүүхэд асарсаны тэтгэмжийг авах боломжийг нээсэн. Ингэснээр **20.000 орчим аавууд тус тэтгэмжид хамрагдахаар** боллоо.

- Үндэсний бахархал, монгол өв соёлыг өвлүүлж, олон улсын стандарт шаардлагад нийцсэн **“Чингис хаан” хаад, язгууртны шинэ музей, Үндэсний номын сангийн шинэ барилга** барьж ашиглалтад оруулахад бэлэн болоод байна.

#### **Гурав. Эдийн засгийн бодлогын хүрээнд:**


- Монгол Улсын эдийн засаг цар тахлын нөлөөгөөр 2020 онд -5,3 хувьд хүрч унасан бол 2021 оны 10 дугаар сарын байдлаар эдийн засаг сэргэж **3.6 хувийн өсөлттэй** байна.



- Монгол Улсын 2021 оны төсвийн урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 102.7 хувийн биелэлттэй, үүнээс нийгмийн даатгалын сангийн орлого төлөвлөсөн хэмжээнээс 322.3 тэрбум төгрөгөөр давж биелэсэн байна.

- Инфляцын түвшин 2021 оны 2 дугаар улирлаас идэвхжиж, 2021 оны 12 дугаар сарын байдлаар **13.4 хувьд хүрээд байна.** Хилийн хязгаарлалт, хил дээрх ачаа барааны бөөгнөрөл, малын гоц халдварт өвчний тархалт, тээврийн зардлын өсөлт, гадаад зах зээл дээрх тухайн барааны үнийн өсөлт зэрэг

нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлт инфляцын дийлэнхийг бүрдүүлж байна.



- “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-г Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 42 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж 2021 оны 11 дүгээр сарын байдлаар ажлын байрыг дэмжих зээлд 21 мянган зээлдэгчийг хамруулж, 1.9 их наяд төгрөг олгож, 86.4 мянган ажлын байр хадгалжээ. Барьцаа хөрөнгийн дутагдалтай нийт 165 иргэн, аж ахуй нэгжид 21.9 тэрбум төгрөгийн зээлийн батлан даалт гаргасан байна бол репо санхүүжилтийн зээлийн хүрээнд нийт 789.8 тэрбум төгрөгийг 2584 зээлдэгчид олгож, 25 мянган ажлын байр хадгалсан байна.

- Ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд нийт 925 тэрбум төгрөгийг 12 мянга орчим зээлдэгчид олгожээ. Барилгын салбарт дам нөлөөгөөр 81 мянган ажлын байр хадгалсан мэдээлэл байна. Хөдөө аж ахуйг дэмжих болон малчдыг дэмжих зээлийн хүрээнд 384.2 тэрбум төгрөгийг 19.7 мянган зээлдэгчид олгожээ.

- 2021 оны 10 дугаар сарын байдлаар гадаад валютын нийт албан нөөц 4.2 тэрбум ам.доллар байна. Энэ нь импортын 7.7 сарын нөөцийг хангахаар байгаа нь олон улсын жишигт түвшнийг бүрэн хангаж байна.

- Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 102 дугаар тогтоолын дагуу олон улсын санхүүгийн зах зээлд жилийн 5.125 хувийн купонтой 5.5 жилийн хугацаатай 600.0 сая ам.долларын Номад бондыг 2020 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр арилжаалж, 2021 оны 4 дүгээр сард төлөх Мазаалай бонд, 2022 оны 12 дугаар сард төлөх Чингис бондуудын тодорхой хэсгийг буцаан худалдан авсан.

- Дулааны IV цахилгаан станцын хүчин чадлыг 46 МВт-аар өргөтгөх ажил дуусч 2021 оны 1 дүгээр сарын 07-ны өдөр сүлжээнд залгасан. Төсөл хэрэгжсэнээр цахилгааны нийлбэр хүчин чадал 89 МВт-аар, дулааны нийлбэр хүчин чадал 75 Гкал/ц-аар нэмэгдэж, уурын турбинуудын АҮК 2.5-3 хувиар нэмэгдэж, жилд 20000 орчим тонн жишмэл түлш, нүүрс хэмнэх юм.

- Богдхан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн бөгөөд уг зам нь Рашаант өртөөнөөс Богдхан уулын урдуур тойрч, Мааньт өртөөтэй холбогдох бөгөөд Төв аймгийн Алтанбулаг, Сэргэлэн сум, Улаанбаатар хотын Баганхангай, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн газар нутгийг дамжин нийт 135.8 км үргэлжлэх зургаан зөрлөг, гурван өртөө бүхий бүтээн байгуулалт юм.

- Оюу Толгой төслийн гаднын хөрөнгө оруулагч талтай хэлэлцээр хийх ажлын явцад үр дүн гарч, хөрөнгө оруулагч тал өмнө нь үүсэн 2.3 тэрбум ам.долларын өрийг 100 хувь барагдуулж, ирээдүйд тооцогдох 22 тэрбум ам.долларын өр үүсэхгүй болсноор Оюу толгой төслийн Засгийн газрын эзэмшлийн 34 хувь Монгол Улсад үнэ төлбөргүй ирэх боломжтой болсон, мөн гүний уурхайн үйлдвэрлэлийг 2022 оны 1 дүгээр сарын 22-нд эхлүүлээ.

#### **Дөрөв. Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд:**

- Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын 2020 оны жилийн дундаж агууламжийг өмнөх дундаж агууламжтай харьцуулахад PM10 тоосонцор 34мкг/м3-ээр буюу 27 хувиар, PM2.5 тоосонцор 11мкг/м3-ээр буюу **18 хувиар буурсан үзүүлэлттэй** байна.

- 2020 онд ойн талбай 18,9 хувь, бэлчээрийн талбай 10,2 хувиар, байгаль экологид учруулсан хохирлын хэмжээ 95 хувь, түймрийг унтраахад зарцуулсан зардал 21,9 хувь, хууль бус бэлтгэгдэж хураагдсан мод 72 шоо метр болж 2019 оны мөн үеэс **70 хувиар буурсан**.

- Хөвсгөл нуурт 1985 онд живсэн “Сүхбаатар” хөлөг онгоцыг нуураас амжилттай татан гаргалаа. Уг онгоц нь нуурын эргээс 110-120 метр, 12-16 метрийн гүнд живсэн байжээ.

#### **Тав. Засаглалын бодлогын хүрээнд:**

- Цахим үйлчилгээний нэгдсэн **www.e-mongolia.mn** порталын гар утасны e-mongolia мобайл аппликейшныг хөгжүүлж 2020 оны 10 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн хэрэглээнд нэвтрүүлээд байна. Тус системээр дамжуулан 2021 оны байдлаар **төрийн 562 үйлчилгээг нэгтгээд байгаа** ба нийт 5,441,581 удаагийн үйлчилгээг цахим хэлбэрээр иргэд, байгууллагуудад амжилттай үзүүлсэн.

- Цахим гарын үсгийн тухай хуулийг 10 жилийн дараа шинэчилж, Кибер аюулгүй байдлын тухай, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай анхдагч хуулийг УИХ-аар батлууллаа.

- Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулав.

- Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон бусад хуулийн төслийг Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн чуулганаар баталсан.

- Засгийн газраас “Монгол Улсын виз олгох журам”-ыг шинэчлэн баталж, 2021 оны 8 дугаар сарын 16-наас шинэчилсэн журмыг мөрдөж эхлэхээр боллоо. Тус журам шинэчлэгдсэнээр Монгол Улсын визийн ангиллууд нэмэгдэж, дипломат, албан, хөрөнгө оруулах, хөдөлмөр эрхлэх, суралцах, гэр бүл, цагаач, хувийн, шашны болон түр ирэх зорилгоор гэж төрөлжүүлж, 64 ангиллын виз олгохоор болж байна.

#### **Зургаа. Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

- Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын 2020 оны 35 дугаар тогтоолоор Нийслэлийн зүүн бүсэд жилд

600 мянган тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулахаар шийдвэрлэж, уурын хатаалгатай тоног төхөөрөмж бүхий үйлдвэрийг 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдөр ашиглалтад оруулсан. “Таван толгой түлш” ХХК-ийн баруун болон зүүн бүсийн үйлдвэр нь 666,815 тонн сайжруулсан түлшийг 686 борлуулалттын цэг, 28 хангамж, 35 нөөцийн агуулахад тээвэрлэн **198,000 айл өрхийг сайжруулсан түлшээр тасралтгүй** ханган ажиллаж байна.

- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн **шинэчилсэн найруулгыг УИХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн чуулганаар баталсан**. Хуульд орон нутгийн чиг үүрэг бүлгийг шинээр нэмж өмчийн захиран зарцуулах эрхийг сум, дүүрэгт шилжүүлж, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж төсвийн төвлөрсөн байдлыг багасгах арга хэмжээг авсан.

- 2021 оны байдлаар барилга байгууламжийн 40 хувь буюу 12 барилгын ажил эхэлсэн. Төслийн талбайд Монголын талаас 450, БНХАУ-ын 65 ажилчин ажиллаж байгаа аж. Шинэ цэвэрлэх **байгууламжийн ажлын явц 35 хувьтай үргэлжилж** байна. 2024 онд цэвэрлэх байгууламжийг барьж дуусгана.

Та бүхэн Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцтай танилцна уу.